

X-70.

ГЭРЛЭХ ЁСЛОЛЫН ОРДОН


ТҮҮХЧИЛСЭН ЛАВЛАГАА

УЛААНБААТАР ХОТ 2009 ОН

5х.

25-24

МАНАЙ БАЙГУУЛЛАГЫН ЭРХЭМ ЗОРИЛГО



САРУУЛ ОРЧИН
СОЁЛТОЙ ҮЙЛЧИЛГЭЭ
ҮҮРДИЙН ДУРСАМЖ
ҮНЭНЧ СЭТГЭЛГЭЭ

Тус ордонд даргаар ажиллаж

байсан хүмүүс : 1. Дамчаа овогтой Дашдэндэв 1976-1985

Орлогч дарга Жигжидсүрэн


Цэрэнбаатар

Амар

Тогоо 1985-1991

Хаймчиг овогтой Оюунчимэг 1991-оноос
одоог хүртэл

Тус ордон анх 25 ажилтантай байгуулагдаж байв.



1250

29 ст

НИЙСЛЭЛИЙН ГЭРЛЭХ ЁСЛОЛЫН ОРДОН

АРХИВИЙН ШИФР

| | |
|--|-------------------------|
| Хөмрөгийн дугаар : | №70 |
| Баримтын оны хязгаар: | 1976-2009 |
| Байнга хадгалагдах хадгаламжийн нэгжийн данс | /1976-2009 оны 195ХН |

НЭРИЙН ӨӨРЧЛӨЛТ

| Д/д | Нэрийн өөрчлөлт | Он |
|-----|---|------------|
| 1. | АДХГЗ-НЫ ИРГЭНИЙ ГЭР БҮЛИЙН БАЙДЛЫГ БҮРТГЭХ ГЭРЛЭХ ЁСЛОЛЫН ОРДОН | 1976-1992 |
| 2. | НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ ГЭРЛЭХ ЁСЛОЛЫН ОРДОН | 1992-1993 |
| 3. | НИЙСЛЭЛИЙН ГЭРЛЭХ ЁСЛОЛЫН ОРДОН | 1993.04.30 |

ХӨМРӨГ ҮҮСГЭГЧИЙН ТҮҮХ

Нийслэлийн Гэрлэх ёслолын ордон нь 1976 оны 06 дугаар сарын 14-ны өдөр Улаанбаатар хотын АДХГЗ-ны Иргэний Гэр бүлийн байдлыг бүртгэх Хэлтэс бөгөөд Гэрлэх ёслолын ордон нэртэй байгуулагдсан.

1976-1991 он хүртэл тус Хэлтэстэй хамт үйл ажиллагаа явуулж байгаад 1992 оны АДХГЗ-ны 10 дугаар сарын 09-ний өдрийн б/222 тоот захирамжаар татан буугдаж Гэрлэх ёслолын ордон биеэ даасан аж ахуйн тооцоонд шилжин өөрөө өөрийгөө санхүүжүүлэх зарчим дээр тулгуурлан ажиллах болсон.

Тус ордон 1976 онд анх байгуулагдсанаас хойш 33 дахь жилдээ үндсэн үйл ажиллагаагаа эрхлэн ажиллаж байна. Монгол зон олны гал голомтыг бадраах уламжлалт зан үйлийг баримтлан, хүмүүний амьдралд тохиолдох хамгийн аз жаргалтай агшинг тэмдэглэн хуримын, гэрлэх ёслолын дахин давтагдашгүй нандин үйл ажиллагааг удирдан зохион байгуулах хүндтэй бөгөөд хариуцлагатай үүрэг хүлээсэн хамт олон юм. Энэ хугацаанд нийт 25.0 мянган залуу хосод үйлчилсэн байна.

Тус ордон нь нийгмийн үнэт зүйл болсон гэр бүлийн ёс суртахууны төлөвшилтөд анхаарал тавьж, сайн сайхныг түгээн дэлгэрүүлэх зорилгоор 1997 оноос эхлэн “Тэнгэрлэг гэр бүл”-ийг шалгаруулан алдаршуулах үйл ажиллагааг улсын хэмжээнд зохион байгуулж ирлээ. Мөн түүнчлэн 25 жил, 50 жил ханилсан хосуудын “Мөнгөн хурим” “Алтан хурим”-ыг ёслол төгөлдөр тэмдэглэж буй нь залуу гэр бүлд үлгэр дууриалтай, тэдэнд бахархах сэтгэгдэл төрүүлсэн, амьдралдаа тэмүүлэлтэй, зорьсон зорилготой амьдрах эрмэлзлэл бий болгодог үр дүнтэй ажлуудыг зохион байгуулж байна.

Тус ордны дэргэд 2006 оноос “Гэр бүлийн сургалтын төв”-ийг ажиллуулж залуучуудын гэр бүлд бэлтгэх, тэдний зан суртахууны төлөвшилд анхааран нийгмийн сэтгэл зүйн чиглэлээр сургалт явуулж байгаагийн зэрэгцээ Нийслэлийн Дүүргүүдийн

Иргэний бүртгэлийн албадтай хамтран жил бүр их дээд сургуулиуд, ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад Гэр бүлийн ёс зүйн чиглэлээр уулзалт, ярилцлага зохион байгуулдаг.

Манай хамт олон хүмүүний амьдрал дахь алтан агшинг цаг алдалгүй, нандин дурсамж дүүрэн үлдээх хариуцлагатай бөгөөд хүндэтгэлтэй албыг чанарын өндөр түвшинд эрхлэн явуулдаг мэргэшсэн хамт олон юм.

ХӨМРӨГИЙН ТҮҮХ

Гэрлэх ёслолын ордон нь 1976 оны 6 дугаар сарын 14-нд АДХГЗ-ны Иргэний Гэр Бүлийн Байдлыг Бүртгэх Хэлтэс бөгөөд Гэрлэх ёслолын ордон нэртэйгээр байгуулагдсан.

АДХ-ны гүйцэтгэх захиргааны Иргэний гэр бүлийн байдлыг бүртгэх хэлтэс нь иргэдийн эцэг тогтоох, овог нэрийн өөрчлөлт, үрчлэлт, төрөгсдөд гэрчилгээ олгох, гэрлэлтийн баталгаа олгох зэрэг ажлыг хариуцаж байгаад 1992 онд “Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн хууль” гарсны дагуу харьяа дүүргүүдэд уг ажлыг хувиарлан хариуцах болж тус хэлтэс татан буугджээ.

Нийслэлийн Засаг Дарын 1993 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн А-96 тоот захирамжаар Нийслэлийн Гэрлэх ёслолын ордон болж залуу хосын хуримын ёслолын үндсэн үйл ажиллагааг явуулах үндсэн үүрэгтэйгээр ажиллаж байна.

Тус ордны архивт 2000 онд Нийслэлийн архивийн албаны ажилтнууд ЭШТБ хийж баримтыг “Он зохион байгуулалтад оруулж эмхлэн цэгцэлсэн байна.

Архив албан хэрэг хөтлөлтийг Монгол улсын засгийн газрын 1995 оны 53 тоот тогтоолоор батлагдсан “Архив албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврын дагуу хөтөлж, эдөр тутмын үлй ажиллагаандаа мөрдлөгө болгож байна. Байнга хадгалагдах 40 ширхэг кадгаламжийн нэгжийг Нийслэлийн Архивийн газрын архивт шилжүүлсэн.

2009 оны байдлаар тус байгууллагын архивт нийтдээ байнга хадгалагдах 195 ш кадгаламжийн нэгж, түр хадгалагдах 82 ш кадгаламжийн нэгж хадгалагдаж байна.